

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/015/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн захирал: М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 61/310
танай _____-ны № _____-т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ

Бидний үзэж байгаагаар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

Хан-Уул дүүргийн гудамжны камерүүдийг эзэнжүүлж, арчлах засварын ажлуудыг хийж гүйцэтгүүлэхээр дүүргийн Засаг даргын нөөц сангаас 982,635.0 мянган төгрөгийн санхүүжилтийг өгсөн нь байгууллагын тайлант оны орлого өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орлогын төлөвлөгөөг 1,313,124.7 мянган төгрөгөөр буюу 52.0 хувиар давуулан биелүүлж, ашгийг 452,568.9 мянган төгрөгөөр өсгөжээ.

C:\Users\zendinere.0\Desktop\2025\Word\... 17.03.2025

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023-12-31	2024-12-31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	290,673,728.48	262,854,092.36
1.1.2	Дансны авлага	1,588,949.31	207,832,634.70
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,386,401.28	71,186,663.73
1.1.6	Бараа материал	190,399,889.35	359,843,393.94
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	485,048,968.42	901,716,784.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	29,245,468.92	47,964,452.86
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29,245,468.92	47,964,452.86
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	514,294,437.35	949,681,237.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	32,156,820.45	14,974,744.05
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	32,156,820.45	14,974,744.05
2.1.1.1	Дансны өглөг	2,508,000.00	14,974,744.04
2.1.1.3	Татварын өр	29,648,820.45	(0.00)
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	32,156,820.45	14,974,744.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	32,156,820.45	14,974,744.05
2.3	Эздийн өмч	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	727,058,117.56	482,137,616.90
2.3.10	Тайлант үеийн ашиг (алдагдал)	(244,920,500.67)	452,568,876.66
2.3.11	Эздийн өмчийн дүн	482,137,616.90	934,706,493.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	514,294,437.35	949,681,237.61

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2023-12-31	2024-12-31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,380,498,393.60	3,308,070,944.56
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	2,380,498,393.60	3,308,070,944.56
5	Хүүний орлого	2,334,449.52	7,519,322.26
8	Бусад орлого	143,604,151.83	521,125,849.64
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,232,389,406.17	3,333,861,809.06
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(506,995,687.05)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(212,948,098.27)	502,854,307.40
19	Орлогын татварын зардал	31,972,402.40	50,285,430.74
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(244,920,500.67)	452,568,876.66
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(244,920,500.67)	452,568,876.66
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(244,920,500.67)	452,568,876.66

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
						Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022-12-31-ний үлдэгдэл	-	-	-	-	727,058,117.57	727,058,117.57
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	727,058,117.57	727,058,117.57
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(244,920,500.67)	(244,920,500.67)
9	2023-12-31-ний үлдэгдэл	-	-	-	-	482,137,616.90	482,137,616.90
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	482,137,616.90	482,137,616.90
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	452,568,876.66	452,568,876.66
17	2024-12-31-ний үлдэгдэл	-	-	-	-	934,706,493.56	934,706,493.56

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2023	12/31/2024
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,778,473,019.52	4,220,088,276.30
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,778,473,019.52	4,220,088,276.30
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,623,350,354.67	4,233,839,912.43
	Ажиллагчдад төлсөн	1,088,646,810.40	1,309,743,617.01
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	124,035,002.99	186,582,268.61
	Бараа материал худалдан авахад төлсөн	31,468,528.54	54,422,940.00
	Ашиглалтын зардалд төлсөн	178,136,324.62	183,815,140.65
	Татварын байгууллагад төлсөн	-	472,519,607.54
	Бусад мөнгөн зарлага	1,201,063,688.12	2,026,756,338.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	155,122,664.85	(13,751,636.13)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,806,636.37	14,067,999.99
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,806,636.37	14,067,999.99
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,806,636.37)	(14,067,999.99)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	141,316,028.48	(27,819,636.12)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	149,357,700.00	290,673,728.48
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	290,673,728.48	262,854,092.36

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.5. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү төгрөгөөр	Зөрүү хувиар
1	Борлуулалтын орлого	2,516,072,130.00	3,829,196,794.20	1,313,124,664.20	1,521.89
2	Үйл ажиллагааны бус орлого	-	7,519,322.26	7,519,322.26	-
3	Нийт орлого	2,516,072,130.00	3,836,716,116.46	1,320,643,986.46	1,524.88
4	Үндсэн болон нэмэгдэл цалин	1,487,671,490.00	1,453,105,101.46	(34,566,388.54)	976.76
5	Нийгмийн даатгалын шимтгэл	185,958,910.00	176,894,494.50	(9,064,415.50)	951.26
6	Бичиг хэрэг	6,500,000.00	7,870,066.59	1,370,066.59	1,210.78
7	Гэрэл цахилгаан	105,658,200.00	95,520,873.49	(10,137,326.51)	904.06
8	Түлш халаалт	55,000,000.00	39,390,308.78	(15,609,691.22)	716.19
9	Цэвэр бохир ус	55,000,000.00	34,407,914.72	(20,592,085.28)	625.60
10	Тээвэр, шатахуун	20,000,000.00	24,784,743.37	4,784,743.37	1,239.24
11	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		14,721,743.29	14,721,743.29	-
12	Шуудан холбоо	8,500,000.00	3,026,976.33	(5,473,023.67)	356.11
14	Нормын хувцас, зөөлөн эдлэл	55,096,010.00	45,816,351.56	(9,279,658.44)	831.57
15	Урсгал засвар, тавилга эд хогшил	266,739,520.00	1,241,067,765.95	974,328,245.95	4,652.73
16	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	31,802,387.55	6,802,387.55	1,272.10
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	214,948,000.00	126,129,522.72	(88,818,477.28)	586.79
18	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	28,719,000.00	(1,281,000.00)	957.30
19	Бусад зардал	-	10,604,558.76	10,604,558.76	-
20	Нийт зардал	2,516,072,130.00	3,333,861,809.06	817,789,679.06	1,325.03
21	Татварын өмнөх ашиг (алдагдал)	-	502,854,307.40	502,854,307.40	-
22	Орлогын албан татварын зардал	-	50,285,430.74	50,285,430.74	-
23	Цэвэр ашиг (алдагдал)	-	452,568,876.66	452,568,876.66	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 74,127.8 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Нийт 1,306.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 384.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 921.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны өглөгийг тайланд тусгаагүй.	1	12,856.0	-	0.0	1	12,856.0	1	12,856.0		
Ажилтны цалингийн нэмэгдлийн тооцооллыг зөрүүтэй бүртгэж тайлагнасан	1	5,130.7	-	0.0	1	5,130.7	1	5,130.7		
Зардлыг зөрүүтэй тайлагнасан.	1	88.2			1	88.2	1	88.2		
Орлогын дэлгэрэнгүй тайланд ерөнхий удирдлагын зардлыг дутуу илэрхийлсэн.	1	56,052.9	-	0.0	1	56,052.9	1	56,052.9		
Дүн	4	74,127.8	-	0.0	4	74,127.8	4	74,127.8	-	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НӨАТ-ийн тайланд орлогыг илүү тусган тайлагнасан байна.	1	921.4					1	921.4				
Цалингаас ХХОАТ-ийг дутуу суутган тооцсон байна	1	384.6	1	384.6								
Ээлжийн амралт тооцоолох ажлын жилийг буруу тооцоолж, ажлаас гарч буй ажилтантай ээлжийн амралтын илүү, дутуу тооцоог үнэн зөв хийдэггүй.	1						1					
Дүн	3	1,306.0	1	584.6	-	0.0	2	921.4	-	0.0	-	0.0

АДБОУС 4000. 16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулсан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 47,489.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Хан-Уул дүүргийн Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 2 төгрөгийн мэдээллийг орхигдуулсан.	1	40,000.0					1	40,000.0
Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	7,489.6					1	7,489.6
Дүн	2	47,489.6	-	0.0	-	0.0	2	47,489.6

5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТБОНӨҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			